



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/190

Мандалговь

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас үерт өртсөн тус сумын 3 өрхийн 2100 малын сэг зэмийг булшлах арга хэмжээнд хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд зарцуулсан шатахууны зардал 2949000 (Хоёр сая есөн зуун дөчин есөн мянга), хүнсний зардал 278460 (Хоёр зуун далан найман мянга дөрвөн зуун жар), нийт 3227460 (Гурван сая хоёр зуун хорин долоон мянга дөрвөн зуун жар) төгрөгийг Засаг даргын нөөцийн зардлаас гаргахыг Тамгын газрын дарга Б.Оюунчимэг, ня-бо О.Бямбасүрэн нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ